



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

19.05.03 онд дугаар
сарын 09-ны өдөр.

Дугаар А.54

Улаанбаатар
хот.

Хүнсний зах ажиллуулах
тухай

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын саналыг үндэслэн хүнсний "Танан эрдэнэ" зах нээж ажиллуулахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнсний зах ажиллуулах үлгэрчилсэн дүрэм батлах тухай Монгол улсын Худалдаа үйлдвэрийн сайдын 1993 оны 440 тоот тушаалын дагуу зохион байгуулж ажиллуулахыг хүнсний "Танан эрдэнэ" зах /н.Сэмжид/-д үүрэг болгосугай.

3. Тус захын үйл ажиллагаанд байнга хяналт тавьж, дэг журам зохион байгуулалт, ариун цэврийн шаардлага хангуулж ажиллахыг Хан-Уул дүүргийн Засаг дарга /Т.Билэгт/-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.Баасанжав

Ц.БААСАНЖАВ